



УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАРТ

АРДЧИЛСАН НАМ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1 дүгээр хороо, Соёл амралтын хүрээлэн,
Гэндэнгийн гудамж-16, 4.5 давхарт Ардчиллын өргөө
E-mail: info@demparty.mn https://www.demparty.mn

2020.12.21 № 01/325-3
танай _____ -ны № _____ т

Хүсэлт гаргах тухай

Содномзундуй овогтой Эрдэнэ миний бие 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн Улсын дээд шүүхийн 01 тоот тогтоолоор Ардчилсан Нам (АН)-ын хууль ёсны эрх бүхий даргаар томилогдсон. Улсын дээд шүүхийн 01 дүгээр тогтоолыг үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдөр С.Эрдэнийг Ардчилсан намын даргаар томилсныг 84ВН/916 тоот регистрийн дугаар бүхий Улсын бүртгэлийн гэрчилгээний бүртгэлд хуульд нийцүүлэн бүртгэж тэмдэглэсэн.

Мөн АН-ын үйл ажиллагаа дүрмийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих, дүрэмд заагдсан хэм хэмжээг хэрхэн зөв кэрэглэн тайлбарлах талаар эцсийн шийдвэр гаргах эрхтэй Намын дүрмийн хяналтын байгууллага болох АН-ын Үндсэн Дүрмийн Хороо (ҮДХ)-ны 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 16 тоот тогтоолоор " . . . С. Эрдэнэ нь АН-ын Их хурлаар хууль ёсны дараагийн дарга сонгогдох өдрийг хүртэлх хугацаанд намын даргын ажлыг үргэлжлүүлэн хаших . . ." тухай Үндсэн дүрмийн тайлбар шийдвэр гаргасан.

Ц.Туваан нь АН-ын 1117237845 дугаар бүхий тамгыг эргүүлэн өгөх шаардлагыг биелүүлэхгүй, удаа дараа АН-ын Үндсэн дүрэм болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн үйл ажиллагаа явуулсаар байгаа тул Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31.1.3 дах хэсгийг баримтлан өргөдөл гаргаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12.1, 12.2.3, 19.4.7 дах хэсгийг баримтлан С.Эрдэнийг Ардчилсан намын даргаар бүртгэсэн бүртгэл өнөөдрийг хүртэлх хугацаанд хүчинтэй хэвээр байгаа тул иргэн Ц.Тувааны ашиглаж буй АН-ын 1117237845 дугаар бүхий тамгыг хүчингүй болгож, АН-ын тамгыг шинээр хийлгэх зөвшөөрөл олгож өгнө үү.

ДАРГА

С.ЭРДЭНЭ